



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/693

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Майкл С. Клеческитэй хийсэн уулзалтын зардалд 1 125 000 төгрөг, Хүнс, хөдөө аж ахуйн яамны дэд сайд Г.Батсууриар ахлуулсан ажлын хэсэгтэй хөрөнгө оруулалт нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан уулзалтын зардалд 3 900 000 төгрөг, Хууль зүйн яамны ажлын хэсгийн бүрэлдэхүүний зардлын дутууд 450 000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 5 475 000 төгрөг /Таван сая дөрвөн зуун далан таван мянга/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



00 2538
D/Zah-A/693-Bo